



**БНМАУ  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

19 91 оны 8 сарын 28

№ 260

Улаанбаатар хот

Халуун ус эмчилгээний  
"Эвлэг" төвийн тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын 16 дахь удаагийн II чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас **ТОГТООХ** нь:

1. Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын харьяа халуун усны 9-р салбарыг нийтийн халуун ус-эмчилгээний "эвлэг" төв болгон үйлчилгээг өргөтгөн аж ахуйн бүрэн тооцоон дээр төрийн өмчид байх бие даасан нэгж болгон 1991 оны 9-р сарын 1-нээс эхлэн Орон сууц нийтийн аж ахуйн 4-р контортой түрээсийн гэрээтэй ажиллуулахаар тогтоосугай.

2. "Эвлэг" төвийн халуун усны үйлчилгээний технологи, инженерийн байгууламж, эмчилгээ эрүүл ахуйн чиглэлээр мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газар /Д.Бямбаа/, Эрүүл мэндийн газар /Т.Буян-Өлзий/-т даалгасугай.

3. "Эвлэг" төвийн байрны инженерийн шугам сүлжээний засварыг түрээслүүлэгч байгууллагын хүч хөрөнгөөр 9 дүгээр сарын 15-ны дотор хийлгэхийг Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газар /Д.Бямбаа/-т даалгасугай.

4. Халуун усны 9 дүгээр салбарыг шилжүүлсэнтэй холбогдуулан Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын 1991 оны төлөвлөгөөнд зохицуулалт хийхийг Нийгэм эдийн засгийн бодлогын зөвлөл /Г.Ганхуяг/-т үүрэг болгосугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

*[Signature]*  
Л.ЭНЭБИШ

*[Signature]*  
Ц.БОЛДСАЙХАН